

SMITTSKYDDSBLAD

Patientinformation

Tuberkulos

Översättning till mongoliska

Version 2022-04-11

Сүрьеэ, өвчтөнд өгөх мэдээлэл

Халдвар хамгааллын эмч нараас өгөх мэдээллийн хуудас.

Та яагаад энэ мэдээллийг авч байна вэ?

Та сүрьеэ өвчинтэй эсвэл тийм байх магадлалтай ба танд эмчилгээ хэрэгтэй. Энэ хуудаст сүрьеэ, түүнийг хэрхэн эмчлэх, та юу хийх ёстой тухай мэдээлэл бий.

Сүрьеэ гэж юу вэ?

Сүрьеэ нь (ТВС эсвэл ТВ гэж нэрлэдэг) *Mycobacterium tuberculosis* нэртэй бактериэр үүсдэг халдварын өвчин юм. Өвчин нь ихэнхдээ уушигны үрэвсэл үүсгэдэг ч биеийн өөр эрхтэн буюу тунгалагийн булчирхай, уушигны гялтан, араг яс, тархи эсвэл бөөрийг өвчлүүлж болно. Халдвар авснаас хойш удаан хугацааны (сар, жилүүд) дараа өвчний шинж тэмдэг ихэнхдээ илэрнэ. Жижиг хүүхэд эсвэл дархлаа султай хүнд өвчин арай хурдан явцтай байх ба заримдаа маш ноцтой байж болно.

Сүрьеэ хэрхэн халдах вэ?

Уушгиндаа сүрьеэтэй хүнээс өвчин халдварлана. Өрөө тасалгаанд ханиахад өөр хүн бактериэй агаарын дуслаар амьсгалж халдвар авч болно. Сүрьеэ эхний ээлжинд өвчтөнтэй ойрын ба удаан харьцаатай хүнд халдана. Тиймд нэг өрхийн хүнд халдах магадлалтай. Эцэг эх нь хүүхэд, ойрын найздаа халдаах боломжтой. Харин богино хугацаанд хавьтсан эсвэл ажил, сургууль дээр түр зуур уулзсан хүнд халдах нь ховор.

Сүрьеэтэй байгааг хэрхэн мэдэх вэ?

Элбэг зовиур нь жин хасагдах, 3-аас илүү долоо хоног үргэлжлэн ханиах, шөнө хөлрөх, халуурах явдал юм. Сүрьеэний бактери хаана байгаагаас хамаарч зовиур өөр өөр байна. Өөр зовиур нь хаван (булчирхайн сүрьеэ) эсвэл өвдөлт (араг яс, хэвлийн сүрьеэ). Сүрьеэний шинж тэмдэг нь хэр удаан өвчилснөөс хамааран хүнээс хүнд өөрөөр илэрч болно – бараг зовиургүйгээс маш ноцтой өвчлөх хүртэл.

Сүрьеэ хэр халдвартай вэ?

Уушигны сүрьеэтэй хүний цэрний шинжилгээнд бактери илэрсэн бол тэр хүн эмчлүүлтэл бусдад маш халдвартай байж болно. Халдаах чадвар нь эмчилгээний эхний долоо хоногуудад эрс багасна. Уушигны бус сүрьеэтэй хүн халдварлахгүй. Сүрьеэтэй бага насны хүүхэд бараг халдварлахгүй. Сүрьеэ нь хувцас эсвэл өөр эд зүйлээр халдахгүй. Өвчин нь гадаа бараг халдварлахгүй.

Сүрьеэ аюултай юу?

Сүрьеэг эмчлэхгүй бол бактери нь тарж, өөр эрхтэнд халдана. Эмчлэгдээгүй сүрьеэ ноцтой гэмтэлд хүргэх, заримдаа амь насанд заналхийлж болно. Бага насны хүүхэд, дархлаа сул хүмүүс сүрьеэгээр ноцтой өвчлөх онцгой их эрсдэлтэй.

Сүрьеэг хэрхэн эмчлэх вэ?

Сүрьеэг өвчин үүсгэгч бактерийг нь устгах эм бэлдмэлээр эмчилнэ. Эмчилгээг урт хугацаанд буюу олон сарын туршид хийнэ. Эмчийн зааврын эмчилгээг хийлгэх нь маш чухал. Зарим эм бэлдмэлийг өлнөөр (голдуу өглөөний хооллолтоос нэг цагийн өмнө) хэрэглэх ёстой. Мөн эмчилгээний эмнүүдээ уухаа мартахгүй байх нь чухал. Эмчийнхээ зааврыг дагах хэрэгтэй. Эмнүүдээ тогтмол уухгүй бол бактериуд эсэргүүцэх чадвартай болж, өвчинг эмчлэхэд хэцүү болж болно. Сүрьеэний эм бэлдмэл, түүнтэй холбоотой эмнэлгийн айлчлал үнэгүй.

Халдварын мөрдөлт – энэ юу гэсэн үг вэ?

Сүрьеэтэй хүмүүсийг олж, эмчилгээ хийлгүүлэх нь маш чухал, ингэснээр нэгд гэмтэл (дээр дурдсан) авах эрсдэл багасна, хоёрт халдвар тархахаас сэргийлнэ. Тиймд сүрьеэтэй өвчтөн та хамт амьдарсан эсвэл уулзсан хүмүүс буюу, танаас халдвар авсан байх эсвэл таныг халдварлуулсан байх магадлалтай хүмүүсийн тухай ярих ёстой. Халдвар авсан хүн өвчлөөгүй байж болно.

Сүрьеэ нь Халдвар хамгааллын хуулиар зохицуулагдана – энэ юу гэсэн үг вэ?

Сүрьеэтэй та бусдад халдвар тараах эрсдэлгүйгээр амьдрах ёстой. Сүрьеэтэй эсвэл тийм байх магадлалтай та эмчийнхээ өгсөн **баримтлах дүрмийг сахих ёстой**:

- Сүрьеэтэй та халдвар тараах чадвартай тул,
 - Тодорхой хугацаанд эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх ёстой болж болно.
 - Эмчилгээгээр халдваргүй болж, эмч таныг бусдад халдваргүй гэж хэлтэл ажил, сургууль, чөлөөт цагийн үйл ажиллагаанд хамрагдаж болохгүй.
- Эмч таныг давтан айлчлалаар ирэх ёстой гэвэл тэгэх ёстой.
- Та нүүх бол тэр тухай эмчдээ мэдэгдэх ёстой.
- Халдварын мөрдөлтөд та оролцох үүрэгтэй.

Та өөрт өгсөн баримтлах дүрмийг буруу гэж үзвэл өөрийн эмнэлгийн бүсийн халдвар хамгааллын эмчтэй холбоо барьж болно.

Та илүү ихийг мэдмээр байна уу?

Сүрьеэний талаарх нэмэлт мэдээлэл дараах хаягт бий

www.1177.se

www.folkhalsomyndigheten.se

Холбоо барих мэдээлэл (Kontaktuppgifter)

Хүлээн авахын нэр (*Namn på mottagningen*)

.....

Таны уулзсан хүн (*Du har träffat*)

Эмч (*Läkare*).....

Сувилагч (*Sjuksköterska*)

Хүлээн авахын утасны дугаар / утасны цаг (*Telefonnummer/telefonid till mottagningen*)